



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

хэвл оны 05 сарын 14 өдөр

Дугаар 8/138

Мандалговь

Г Архигүй өдөр болгох тухай Г

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Дэлхийн гэр бүлийн өдрийг 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр болгосонтой холбогдуулан тухайн өдөр архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэхийг аймгийн хэмжээнд хориглосугай.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг ханган 5 дугаар сарын 15-ны өдөр архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

Гурав. Гэр бүлийн өдөр олон нийтийн хэв журмыг сахиулан гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж ард иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010393